

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан .....	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл .....	8
2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудад хийсэн аудитын дүнгийн талаар.....	8
2.8.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар.....	8
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11 Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал .....	11
3.1 Авлага, өр төлбөр .....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	16
5. Хавсралт .....	17
5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл .....	17

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
НХС	Нийгмийн халамжийн сан



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА Б.НЯМДАВАА  
ТАНАА

2019.03.25 № 06/562  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Нийгмийн халамжийн сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Нийгмийн халамжийн сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийгмийн халамжийн сангийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудитын тайлан

### 2.1 Оршил

Нийгмийн халамжийн сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Б.Нямдаваа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Нийгмийн халамжийн сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн халамжийн сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 05-наас 03 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ж.Болормаа, Э.Энхбаатар нар хэрэгжүүлэв.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/259 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Нийгмийн халамжийн сангийн талаарх мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

#### **Эрхэм зорилго**

Нийгмийн халамжийн сан нь эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

#### **Үйл ажиллагааны чиглэл:**

Нийгмийн халамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар Нийгмийн халамжийн үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна гэж тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр;
- Нийгмийн халамжийн тэтгэмж;
- Нийгмийн халамжийн үйлчилгээ;
- Нийгмийн хөгжлийн үйлчилгээ.

Нийгмийн халамжийн сангийн удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль



- Шилэн дансны тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Ахмад настны тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийгмийн халамжийн сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Нийгмийн халамжийн сангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Нийгмийн халамжийн сан нь нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Нийгмийн халамжийн сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Дотоод аудитын алба Хөвсгөл, Хэнтий, Сүхбаатар, Өмнөговь аймгийн ХХҮГ, Багахангай, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн ХХҮХ-ийн нийгмийн халамжийн сангийн 2017, 2018 оны эхний хагас жилийн хөрөнгийн бүрдүүлэлт зарцуулалтад төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж зөвлөмж өгч ажилласан ба зөвлөмжийн биелэлтийг Хөвсгөл аймагт 84.2 хувь, Сонгинохайрхан дүүрэгт 79.3 хувь, Чингэлтэй дүүрэгт 62.1 хувь, Багахангай дүүрэгт 69.2 хувьтай гэж дүгнэжээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Нийгмийн халамжийн сангийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд

үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийгмийн халамжид олгосон санхүүжилтийн гүйцэтгэлтэй холбоотой юм.

Нийгмийн халамжийн сангийн 2018 оны нийт зардал 364,790.6 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 3,647.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэл дунд гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 31 байгууллага, нэгжийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулахаас 29 байгууллага аудитад хамрагдаж, 1 байгууллагад итгэл үзүүлж, 1 тайлан түүврээр аудитад хамрагдсан байна.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	29	1	1	0
	<b>Дүн</b>	29	1	1	0

Аудитад хамрагдсан төсвийн шууд захирагчдын 29 санхүүгийн тайлангаас “Зөрчилгүй” 28, “Хязгаарлалттай” 1 санал дүгнэлт авснаас 6 санхүүгийн тайланд гэрээгээр аудит хийлгэсэн байна.



### 2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Нийгмийн халамжийн сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 137.6 сая, төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд 34.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 10.2 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулав.

Нийгмийн халамжийн сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

*/сая төгрөг/*

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ	2	3,155.8	-	-	1	24.4	1	3,131.3
2	ТШЗ	9	137.6	2	1.3	1	63.4	6	72.8
	<b>Дүн</b>	<b>11</b>	<b>3,293.4</b>	<b>2</b>	<b>1.3</b>	<b>2</b>	<b>87.9</b>	<b>7</b>	<b>3,204.2</b>

### 2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудад хийсэн аудитын дүнгийн талаар

Нийгмийн халамжийн сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 30 тайлан нэгтгэгдсэнээс 28 тайлан зөрчилгүй, Налайх дүүргийн НХС-гийн санхүүгийн тайлан хязгаарлалттай дүгнэлт авч, Баян-Өлгий аймгийн НХС-гийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Дархан-Уул аймгийн НХС нь ахмад настанд насны хишиг тооцож олгохдоо хуульд заасан насны хязгаар, хувь хэмжээг мөрдөөгүйгээс 5 ахмадад 0.2 сая төгрөг дутуу, 12 ахмадад 0.7 сая төгрөг илүү олгосон, Дундговь аймгийн НХС нь 2018 оны 5 дугаар сард ажилдаа орсон эхэд 6 сар нийт 0.3 сая төгрөгийн цалинтай ээжийн тэтгэмж олгосон зэрэг зөрчил илэрсэн байна.

Мөн Нийгмийн халамж, үйлчилгээний мэдээллийн систем буюу waic програмд өөрчлөлт оруулж, тэтгэвэр, тэтгэмжийн буцаалтыг бодит гүйцэтгэлээр бүртгэдэг болох, төсвийн төлөвлөлтийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн, үр ашигтай байхаар төлөвлөж байх зэрэг зөвлөмжүүд өгөгдсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын хугацаанд Нийгмийн халамжийн сангийн 2018 оны санхүүгийн тайланд түүврээр аудит хийсэн болно.

### 2.8.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг

алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд тусгаж, бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### **Асуудал 1: Хүүгийн орлого**

Тайлант онд 166.0 сая төгрөгийн хүүгийн орлого төвлөрүүлсэн боловч санхүүгийн үр дүнгийн тайланд 155.8 сая төгрөг буюу 10.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Шийдэл: Аудитын явцад залруулсан.

#### **Асуудал 2: Зардал**

Улсын мэдээллийн маягт хэвлүүлэх зардлаас 14.5 сая төгрөгөөр Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, 9.9 сая төгрөгөөр хуулийн эмхэтгэл ном хэвлүүлсэн нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “тэтгэвэр, тэтгэмжийн сангийн хөрөнгийг зөвхөн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид зөрцуулна”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдэл: Албан шаардлага өгсөн.

### **2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

### **2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Нийгмийн халамжийн сангийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 1 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 375,064.9 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 362,389.0 сая төгрөг буюу 96.6 хувь, зардлын нийт гүйцэтгэл 361,835.2 сая төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэний тэтгэмжийн шинэ хөтөлбөр тайлант онд хэрэгжээгүйгээс шалтгаалжээ.

### **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Нийгмийн халамжийн сан нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын шилэн дансны вебсайтад холбогдох мэдээллийг оруулдаг ба тайлант хугацаанд нийт 5 төрлийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Нийгмийн халамжийн сангийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Нийгмийн халамжийн сангийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй, анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Авлага, өр төлбөр**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 0.1 сая төгрөгийн авлага, 3,131.3 сая төгрөгийн өр төлбөр тайлагнаснаас 80 хувь буюу 2,496.9 сая төгрөг нь цалинтай ээж хөтөлбөрийн өр төлбөр байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1-д “төсвийн зарчмыг мөрдлөг болгох” гэсэн шаардлагыг баримталж төсвийн төслийг боловсруулах, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлтүүд	2017 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
3.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
3.1.2.1	Банкинд байгаа бэлэн мөнгө	247,509.8	858,677.2
3.2.1.1	Авлага	100.0	101.5
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>247,609.8</b>	<b>858,778.7</b>
	Эргэлийн бус хөрөнгийн дүн		
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>247,609.8</b>	<b>858,778.7</b>
4.1	<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>	0.0	0.0
4.1	Өр төлбөр	0.0	0.0
4.1.3.1	Олгогдоогүй тэтгэмж	342,652.8	3,131,314.7
2.1.1	<b>Богино хугацаат өр төбөрийн дүн</b>	<b>342,652.8</b>	<b>3,131,314.7</b>
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
	<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>342,652.8</b>	<b>3,131,314.7</b>
5.1.1.1	Эздийн өмч	0.0	0.0
5.1.1.1	Засгийн газрийн сан	0.0	0.0
5.1.1.2	Хуримтлагдсан үр дүн	<b>(95,042.9)</b>	<b>(2,272,536.0)</b>
5.1.1.3	Өмнөх оны үр дүн	(34,622.0)	17,961.9
5.1.1.4	Тайлант оны үр дүн	(60,420.9)	(2,290,497.9)
5.1.1.5	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>(95,042.9)</b>	<b>(2,272,536.0)</b>
	<b>Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>247,609.8</b>	<b>858,778.7</b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

1	Сангийн орлого	Өмнөх он	Тайлан он
13	Татаас ба санхүүжилтийн орлого	321,745,300.1	375,064,902.1
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /улсын төсвөөс /	321,745,300.1	375,064,902.1
14	Үйлчилгээний орлого	111,344.0	258,787.2
	Сангийн чөлөөт үлдэгдэлийг банкинд хадгалуулсаны хүүгийн орлого	65,528.9	155,809.0
	Бусад эх үүсвэр	45,815.0	102,978.2
<b>1</b>	<b>Сангийн орлогын дүн</b>	<b>321,856,644.1</b>	<b>375,323,689.3</b>
27	<b>Сангийн үйл ажиллагааны зардал</b>		
	Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	138,259.3	138,260.0
	Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	4,679,796.3	5,109,008.6
	Алдарт эхийн одонтой эхэд олгосон мөнгөн тэтгэмж	28,841,339.7	29,037,584.7
	Насны хишиг	19,921,001.9	20,746,219.2
	Цалинтай ээж хөтөлбөр	0.0	94,059,115.6
	Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөр	0.0	5,170,920.4
	Ахмад настны бусад хөнгөлөлт	0.0	659,128.4
	Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	257,652,900.0	209,019,818.0
	Банкны үйлчилгээний шимтгэл	11,765.7	53,754.9
	Дотоод албан томилолт	25,820.1	42,873.7
	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	116,114.4	128,789.4
	Улсын мэдээллийн маягт	158,746.6	159,578.9
	Бусдаар гүйцэтгэх нийтлэг ажил үйлчилгээ	388,419.2	465,594.6
	<b>Сангийн үйл ажиллагааны зардалын дүн</b>	<b>311,934,163.5</b>	<b>364,790,646.2</b>
	Төсөвт төвлөрүүлэх	9,982,901.4	12,823,541.0
	<b>САНГИЙН НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>321,917,065.0</b>	<b>377,614,187.2</b>
	<b>ТАЙЛАНТ ҮЕИЙН ҮР ДҮН</b>	<b>(60,420.9)</b>	<b>(2,290,497.9)</b>



### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

КОД	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Өмнөх он	Тайлант он
1	<b>Сангийн орлого</b>	321,856,644.1	375,323,689.3
1 3	Татаас ба санхүүжилтийн орлого	321,856,644.1	375,064,902.1
1 3	Улсын төсвөөс	321,745,300.1	375,064,902.1
1 4	Сангийн чөлөөт үлдэгдэлийг банкинд хадгалуулсаны хүүгийн орлого болон бусад орлого	111,344.0	258,787.2
<b>Сангийн орлогын дүн</b>		<b>321,856,644.1</b>	<b>375,323,689.3</b>
2 7	Төрөлжсөн асрамж үйлчилгээ	138,259.3	138,260.0
2 7	Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	4,575,701.1	5,032,183.4
2 7	Алдарт эхийн одонтой эхэд олгосон мөнгөн тэтгэмж	28,687,413.5	28,860,424.7
2 7	Банкны үйлчилгээний шимтгэл	11,765.7	53,754.1
2 7	Дотоод албан томилолт	25,820.1	42,873.7
2 7	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	116,114.4	128,789.4
2 7	Улсын мэдээллийн маягт	158,746.6	159,578.9
2 7	Бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг ажил үйлчилгээ	388,419.2	465,594.6
2 7	Насны хишиг	19,836,470.5	20,499,660.7
2 7	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	257,652,900.0	209,019,818.0
2 7	Ахмад настны бусад хөнгөлөлт	-	652,940.4
2 7	Цалинтай ээж хөтөлбөр	-	91,562,174.1
2 7	Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөр	-	5,043,280.4
<b>Сангийн үйл ажиллагааны зардлын дүн</b>		<b>311,591,610.6</b>	<b>361,659,332.9</b>
2 7	Төсөвт төвлөрүүлсэн дүн	9,982,901.4	12,823,541.0
2 7	Урьд оны олгогдоогүй мөнгөний зарцуулалт	140,359.5	229,647.9
<b>НИЙТ САНГИЙН МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЗАРДЛЫН ДҮН</b>		<b>321,714,871.6</b>	<b>374,712,522.0</b>
	Сангийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	141,772.4	611,167.3
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>105,737.4</b>	<b>247,509.8</b>
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>247,509.8</b>	<b>858,677.2</b>

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Цөөнхийн хувь оролцоо	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>1</b>	<b>Оны эхний үлдэгдэл</b>	<b>-95,042.9</b>	0.0	<b>-95,042.9</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		0.0	0.0
<b>3</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>		0.0	0.0
<b>8</b>	<b>Үлдэгдэл</b>	<b>-95,042.9</b>	0.0	<b>-95,042.9</b>
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	113,004.8	0.0	113,004.8
<b>10</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>113,004.8</b>	0.0	<b>113,004.8</b>
14	Тайлант үеийн үр дүн	-2,290,497.9	0.0	-2,290,497.9
<b>15</b>	<b>Үлдэгдэл</b>	<b>-2,272,536.0</b>	0.0	<b>-2,272,536.0</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Сангийн орлого	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>247,509.8</b>		
Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ	138,260.0	138,260.0	0.0	100
Ахмад дайчид Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	6,428,400.0	5,127,926.3	1,300,473.6	79.7
Ахмад настануудад үзүүлэх хөнгөлөлт	1,125,000.0	652,940.4	472,059.5	-
Алдарт эхийн одонтой эхэд олгосон мөнгөн тэтгэмж	29,449,000.0	28,940,229.7	508,770.2	98.2
Насны хишиг	20,500,000.0	20,553,760.7	(53,760.7)	100.2
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	209,569,060.0	209,019,818.0	549,242.0	99.7
Нийгмийн халамжийн бусад хөнгөлөлт, тэтгэмж	96,840,000.0	96,605,454.6	234,545.3	99.7
Хичээл үйлдвэрлэлийн зардал	217,800.0	128,789.4	89,010.5	59.1
Бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг бараа ажил үйлчилгээ	466,191.0	465,594.6	596.3	99.8
Улсын мэдээлэлийн маягт бэлтгэх	198,000.0	159,578.9	38,421.0	80.6
Дотоод албан томилолт	50,827.1	42,873.7	7,953.3	84.3
Ядуу өрхийн тэтгэмж	10,082,364.0	-	10,082,364.0	-
<b>Сангийн үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>375,064,902.1</b>	<b>361,835,226.7</b>	<b>13,229,675.3</b>	96.4
<b>САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>375,064,902.1</b>	<b>362,389,041.0</b>	<b>12,675,861.0</b>	96.6
<b>УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ</b>	<b>375,064,902.1</b>	<b>362,389,041.0</b>	<b>12,675,861.0</b>	96.6
Тохируулгын дүн		57,353.0		
<b>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>	<b>-</b>	<b>858,677.2</b>		

## 5. Хавсралт

### 5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

<b>Огноо:</b>	<b>Аудитын нэр:</b>	<i>Нийгмийн халамжийн сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит</i>	
2019/03/13		<b>Аудитын код:</b>	САГ-2019/12/СТА-ЗГТС
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	Нийгмийн халамжийн сан		<b>сая төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл		Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Албан тушаал	Овог нэр
<b>A</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>
1	Улсын мэдээллийн маягт хэвлүүлэх зардлаас 14.5 сая төгрөгөөр Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, 9.9 сая төгрөгөөр хуулийн эмхэтгэл ном хэвлүүлсэн байна.	24.4	Албан шаардлага	2019 03.13	Дарга Нягтлан бодогч	Б.Нямдаваа Д.Билэгмаа
2	Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайланд 0.1 сая төгрөгийн авлага, 3,131.3 сая төгрөгийн өр төлбөр тайлагнаснаас 80 хувь буюу 2,496.9 сая төгрөг нь цалинтай ээж хөтөлбөрийн өр төлбөр байна.	3,131.3	Зөвлөмж	2019 03.13	Дарга Нягтлан бодогч	Б.Нямдаваа Д.Билэгмаа
Нийт		3,155.7				



